

ДеФакто **ТОЙМ**

➤ **КАПИТАЛ БАНКНЫ
ДАМПУУРЛЫН ЦААНА**

➤ БАГШИЙН ХӨГЖИЛ –
УЛСЫН ХӨГЖИЛ

➤ ТӨМӨР ЗАМАА
ЭХЛЭЭД ХААШАА
ТАВИХ ВЭ?

VII HYYPT

ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

УЛС ТӨРЧДИЙН
Ахиж хурал

II HYYPT



ЭРҮҮЛ МЭНД

Б.Цэцэгсайхан

Хавдрын үндэсний зөвлөл
ТББ-ын гүйцэтгэх захирал,
анагаах ухааны доктор

ВАКЦИНЫГ
ЭСЭРГҮҮЦДЭГ
ХҮМҮҮСТ
ДАЙХ ҮГ

IV HYYPT

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЭЛНЭ


ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2019.04.17, №93

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС. ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.defacto.mn



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

УЛС ТӨРЧДИЙН

(1990.02.24)

Анхны хурал

Өдрийн сонин дээр Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдоржийн өдрийн тэмдэглэлийн цуврал гарч байна. 2019 оны 4-р сарын 11-ний дугаарт гуч шахам жилийн өмнөх нэгэн хурлын тухай тэмдэглэл нь хэвлэгджээ. Энэ тэмдэглэлд дурдсан Монголын улс төрийн шинэ хүчнүүдийн анхны хурлыг Монголын Оюутны Холбоо (МОХ) санаачлан зохион байгуулсан юм. Миний бие тус хурлыг хамтран удирдаж, бас тэмдэглэл хөтөлсөн тул энд түүнийгээ анх удаа уншигчидтайгаа хуваалцаж байна.

“1990.02.24. БЯМБА.

- 08:30.** МХЗЭ-ийн ТХ-ны аппаратын мэдээлэл
-Би ОУОХ-ны өөрчлөлт, МОХ-ны тухай ярилаа.
Олон хүний асуултанд хариулсны дотор
-МХЗЭ-ийн ТХ-ны гишүүний хувьд МХЗЭ-ийн онц их хурлыг яаралтай хуралдуулах санал тавьлаа.
- 10:30.** “Монгол Пресс”-ийн сурвалжлагч Л.Гантуяад ОУОХ, МОХ-ны өнөөгийн байдлын тухай ярилцлага өглөө.
- 14:30.** МОХ-ны дарга байсан (3 хоногийн өмнө МОХ-ны тэргүүлэгчдийн хурлаар больсон), ТХ-ны НБД Г.Ганболдтой уулзаж МОХ-ны бодит байдлыг ярилцлаа.
- 16:00-21:00.** МУИС 3-р байранд (хуучин Дээд Боловсролын хороо) дараах бүрэлдэхүүн цугларав.

Ардчилсан хүчний хамтарсан хуралдаан:

1. МОХ: Л.Болд, Д.Жаргалсайхан, Зориггоо (оюутан), Рэнцэнтавхай
2. Шинэ Дэвшил Холбоо: Батсүх (багш), Б.Сундуй, Ш.Шагдарсүрэн, Ж.Бор
3. Ардчилсан Социалист Хөдөлгөөн: Ч.Лхагважав, Р.Хатанбаатар, П.Улаанхүү, Р.Гончигдорж
4. Монголын Ардчилсан Холбоо: Батсүх.Я, Жаргалсайхан (Буян), Элбэгдорж (Улаан Од), Төмөрбаатар

Дөрөв дөрвөн хүнтэй уулзаж, хоёр асуудлаар маш удаан маргаж ярилцав.

1. Ямар үндсэн байр суурин дээр нийлж болох вэ?
2. 3-р сарын 4-ний бүх нийтийн жагсаалыг зохион байгуулах талаар

Дараах асуудлаар тус тусын байр суурийг илэрхийлэх

МОХ (ОНБ)	Шинэ Дэвшил Холбоо	Монголын Ардчилсан Холбоо	Ардчилсан Социалист Хөдөлгөөн
- Намын онц их хурал, НТХ бүрэлдэхүүнийг өөрчлөх - АИХ – Онц чуулган. Үндсэн хууль өөрчлөлт. Чөлөөт сонгууль	- УТТ-г огцруулах - Эвслийн Засгийн газар байгуулах	- УТТ-г тэр чигээр нь огцруулах. Учир нь өнгө солино. - Эвслийн Засгийн газар байгуулах - Ардын онцгой эрхэт комисс байгуулах	- Зөвлөлтийн Засгийн газрын бодлогод, явуулгад автагдахгүй. - Дугуй ширээнд ярилцлага явуулах - Ардын түр хурлыг байгуулах
Хамтарсан цуглааны гол шаардлагыг тохирвол нийтэд мэдэгдэж МОХ-ны жагсаалын дараа – хамтарч болно. 12:00-оос МОХ Сүхбаатарын талбайд биш.	3-р сарын 4-ний цуглаанд хамтрах. 13:00-д	3-р сарын 4-нд цуглааныг орон даяар хийнэ. Хамтарвал сайн. 13:00-д. Заавал Сүхбаатарын талбайд.	3-р сарын 4-нд цуглаан хийх. 13:00-д. Сүхбаатарын талбайд биш, өөр газар.



ОНЦГОЙЛЖ ТЭМДЭГЛЭВЭЭС:

**Монголын Ардчилсан Холбооны
Б.Жаргалсайхан (Буянт Хоршоолол):**

- Содном бол Цэдэнбал шиг орос авгайтай, Зөвлөлт талын хүн. Бидэнд тэр гарын үсэг зурсан нууц баримт байна. ЗХУ-аас 1,3 миллиард долларын өр тавьж, ахиад монголыг худалдсан.
- Өчигдөр Зөвлөлтийн элчин сайдын яаман дээр элчин Ситнихов хэвлэлийн бага хурал хийж “яахав бид танай малчдад 25 сая рубль лаа, ахуйн хэрэглээний юм өгнө” гэлээ.
- Одоогийн намын удирдлага гэмт хэрэгтнүүд учир тэдэнтэй нэг ширээний ард суухгүй.

**Монголын Ардчилсан Холбооны
Элбэгдорж (Улаан Од сурвалжлагач):**

- МОХ-г 3-р сарын 4-ний Бямба гарагт бүх нийтийн хичээл хаяхыг уриалав. (зохиохыг)
- Хэрэв хичээл хаяхгүй бол материал үйлдвэрийн салбарт ажил хаяхыг зохионо гэлээ.
- 3-р сарын 3-4 бол Хувьсгалын өдрүүд, цус ч урсаж болох юм. Монголын Ардчилсан Холбоо Улаанбаатарт гэхэд 102 салбартай.
- Бид одоохон улс орныг

өөрчлөхгүй бол зун гадаадын оюутнууд ирээд чөмөдантайгаа жагсах байх.

Эцэст нь Монголын Ардчилсан Холбоо (Элбэгдорж) Шинэ Дэвшил Холбоо (Батсүх) Ардчилсан Социалист Хөдөлгөөн (Гончигдорж) МОХ (Жаргалсайхан) нар ажлын групп болон дараах баримтыг боловсруулж ороход, хамтран баталсан болно.

Үүнд:

1. Хамтарсан мэдэгдэл БНМАУ, АИХ, МАХН-ын ТХ, СНЗ-д гаргалаа.
2. Уриалга БНМАУ батлан хамгаалах зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд, НАХЯ-ны нийт бие бүрэлдэхүүнд.

Хамтарсан мэдэгдэлд:

1. МАХН-ын Онц их хурлыг 3-р сард хуралдуулж НТХ бүрэлдэхүүнийг өөрчлөх, нам төрөөс үйл ажиллагаа тусгаарлах.
2. АИХ-ын онц чуулганыг хуралдуулж Ардын түр их хурлыг байгуулах, улс төрийн бүх хүч тэгш эрхтэй оролцож чөлөөт сонгуулиар Ерөнхийлөгч сонгох.
3. Төрийн тусгаар тогтнол, улс үндэстний эв нэгдэл, ард түмний аюулгүй байдлыг эрхэмлэх.

Уриалгад:





1. Дээрх хоёр яамны нийт бие бүрэлдэхүүнд ямар ч нөхцөлд ард түмнийхээ эсрэг зэвсэг үл хэрэглэхийг уриалсан.

Шийдвэр:

1. 3-р сарын 3-нд 09:00 цагаас Сүхбаатарын талбайд төлөөлөгчид цуглаж, 10:00 цагт Батмөнх даргад хамтарсан мэдэгдэл гардуулах (оюутан хичээл хаяхыг МОХ зөвшөөрөөгүй)
2. 3-р сарын 4-нд 13:00 цагт цуглаан хийх. Хамтарсан мэдэгдлийн хариугаа Батмөнх даргаас авах.
3. Сүхбаатарын талбайд хийхийг тохироогүй. Монголын Ардчилсан Холбоо шаардсан боловч энэ талаар 2-р сарын 27-нд 18:00 цагт Залуус танхимд ахиж уулзаж ярилцах.

21:30-22:10. МУИС Оюутны зөвлөл дээр ирж 20 гаруй оюутнуудад хамтарсан цуглааны үр дүнг танилцуулахад өндөр сэтгэгдэлтэй хүлээж авч, бид дөрөвт баяр хүргэв.

22:10-23:00. Л.Болдын өрөөнд бид хоёр уулзаж МОХ-ны онц IV бага хурлыг зохион байгуулах тухай ярилцав”



Жич: Би Олон улсын оюутны холбоонд МОХ-г төлөөлж Прага хотод ажилладаг байсан. Улаанбаатарт ирж 1990.02.18-ны Ням гарагт Монголын Ардчилсан Холбооны анхдугаар их хуралд оюутан П.Цэнгүний (одоо Алтан Тариа компани) хамт төлөөлөгчөөр ирж оролцсон.

Би өдрийн тэмдэглэлээ шөнө нь сууж, эрээцсэн цаасаа эмхлэн, буулгадаг байлаа. Улс төрийн хүчин гээд өөрсдийгээ нэрлэсэн байгууллагуудыг оюутнууд маань олж уулзан, тэднийг урин, яаж хамтарч, хүчээ нэгтгэх тухай ярилцах шаардлага тулгараад байлаа.

Энэхүү анхны уулзалтад олон хүмүүс ирж, зохион байгуулалт муу, хүн бүр үг хэлэх гээд зүтгэж байсан тул, Гончигдорж багийнн саналаар дөрвөн байгууллагаас, дөрөв дөрвөн хүн суугаад, дөрвөлжин хэлбэрээр ширээгээ байрлуулан хэлэлцэх болж бусад нь тарснаар, уулзалт жигдэрсэн билээ.

Ямар ч гэсэн шинэ монголын төр засгийг яаж өөрчлөх тухай уртал хэлэлцээний эцэст анхны албан мэдэгдлийг гаргасан юм. Түүнийг хожим нь МУ-ын Их хурлын дарга, Ерөнхийлөгч болох хувь тавилантай хоёр эрхэмтэй хажуу өрөөнд орж, цаасан дээр буулгасан түүх ийм юм.

Энэ дөрвөн байгууллагаас албан ёсны, төрд бүртгэлтэй, өөрийн тамга, бичгийн машинтай ганц байгууллага нь Монголын Оюутны Холбоо байсан. Монголын Ардчилсан Холбоо тэгэхэд нам болоогүй байсан ч, эвслийн Засгийн газар байгуулна гэж байлаа.

Ардчилсан дөрвөн хүчний дараагийн уулзалт 1990.02.27-д 18:30-аас болсон. Тэмдэглэл нь бас бий. Энэ өдөр билгийн тооллын XVII жарны төмөр морин жилийн шинийн хоёрон байлаа.

2019.04.17



НИЙТЛЭЛ

Б.ЦЭЦЭГСАЙХАН*Хавдрын үндэсний зөвлөл ТББ-ын гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор*

ВАКЦИНЫГ ЭСЭРГҮҮЦДЭГ ХҮМҮҮСТ ДАЙХ ҮГ

Хүмүүс бид аливаа зүйлийг хурдан мартах юм. Вакциныг эсэргүүцдэг хүмүүст өмнөх зууны гашуун түүхээс сануулан хуваалцъя. Энэхүү зурган дээр байгаа төхөөрөмжийг ямар учиртай гэдгийг олон хүн асуух нь лавтай. Тэгвэл энэ бол 20-р зууны эхэн үед хүн төрөлхтнийг хамгийн их айдаст автуулж байсан өвчний нэг болох “полиомиелит” буюу халдварт саагийн хүндрэлийн улмаас үлдсэн амьдралаа өнгөрөөдөг байсан “төмөр уушиг” гэгддэг төхөөрөмж юм. 1900 оноос эхэлсэн халдварт саа өвчин, 1940-өөд оноос эхлэн дэлхий даяар дэгдэж жилд хагас сая хүн өвдөн, хэдэн зуун мянган хүүхэд насан туршдаа хөгжлийн бэрхшээлтэй болж үлддэг байжээ. Дэлхийн хэмжээнд 20 гаруй сая хүн энэ өвчний улмаас тахир дутуу болсон байдаг байна.

Хамгийн аюултай нь халдварт саагийн вирус амьсгалын булчинг ажиллагаагүй болгох тохиолдол байсан бөгөөд амийг нь аврахын тулд “төмөр уушиг” буюу эерэг даралттай төмөр камер дотор насан туршид нь амьдруулдаг байлаа. 1950-аад онд эмнэлгүүд ийм л дүр зурагтай, саагийн тасаг тэр чигээрээ уг өвчнөөр өвдсөн, “төмөр уушиг”-нд амьдардаг өвчтөнүүдээр дүүрэн байж.



2009 онд Австралид нас барсан эмэгтэй хамгийн олон жил буюу 83 насныхаа амьдралын 60 жилийг ийм “төмөр уушиг” дотор өнгөрөөсөн хүнээр тодорч Геннисийн номонд орж байсан. Харин өнөөдрийн байдлаар Америкийн Далласт амьдарч буй 72 настай Пол Александр бол “халдварт саагийн улмаас насан туршдаа “төмөр уушиг” дотор амьдарч буй, амьд үлдсэн цөөн хэдхэн хүний нэг юм. Тэрээр энэ өвчин дахиж битгий гараасай гэдэг бодол тээн өөрийн туулж өнгөрүүлсэн амьдрал, түүхийн талаар дурдатгал ном бичиж, хойч үедээ энэ аймшигт өвчний талаар хуваалцаж буй аж.



Тэгвэл хүн төрөлхтөн 1955 онд Америк эрдэмтэн Жонас Салкийн зохиосон саагийн эсрэг вакцины ачаар энэ аймшигт вирусн дэгдэлтийг зогсоож, 1988 оны ДЭМБ-ын 41-р чуулганаар энэ өвчнийг 2000 он хүртэл устгах зорилт тавьж байжээ. Харин өнөөгийн байдлаар дэлхий даяар 3 голомтоос бусад бүх газарт бүрэн устгаж чадсан билээ. Манай улс 1970-аад оноос халдварт саагийн эсрэг вакциныг хийж эхлэн 2001 он гэхэд Монгол улсад полиомиелит өвчнийг устгасныг баталгаажуулсан гэрчилгээг авч байсан нь эрүүл мэндийн салбарынхны үе үеийнхний түүхэн ололт, ялалт байсан юм.

Хүүхдийг бүх насаар нь тахир дутуу болгодог полиомиелит хэмээх аюулт өвчний дараагаар вакцины тусламжтайгаар устгах өвчний тоонд

улаан бурхан өвчин, харин сүүлийн жилүүдэд умайн хүзүүний хавдар орж байна.

Вакцин буюу халдварт өвчнөөс сэргийлэх ерөндөг, хүн төрөлхтний түүхэн ололт амжилтын нэгийг эсэргүүцэж худал үнэн мэдээлэл тараадаг хүмүүст вакцин байхгүй байхад хичнээн саяараа хэрхэн өвдөж, нас барж, амьдралынхаа туршид тахир дутуу болж байсныг ганц өвчний жишээн дээр харуулахад энэ. Полиомиелит эсвэл улаан бурхан өвчнийг устгасныг батлаж өгч буй гэрчилгээ нь тухайн өвчин дахин гарахгүй гэсэн үг хараахан биш. Вакциныг эсэргүүцдэг, бусдыг турхирдаг хүмүүсийн уршгаар устгасан гээд тайвширсан өвчний дэгдэлт гарвал хичнээн хүний амь нас хохирохыг хэн ч таашгүй.

2019 оны 4-р сар

“ЭРХ ЧӨЛӨӨ”

ГУРВАЛ НОМ


Интерном номын
дэлгүүрийн бүх салбаруудаар
худалдаалагдаж байна.

+(976) 9410 9342

The Defacto Gazette

INFORMING | INSPIRING | EMPOWERING

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН



2019 ОНЫ II УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

УЛИРЛЫН ЗАХИАЛГА: 30.000₮



МОНГОЛ
ШУУДАН

7007-8916



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.04.14-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

КАПИТАЛ БАНКНЫ ДАМПУУРЛЫН ЦААНА

Үйл явдлын товч:

Монголбанк өнгөрсөн Даваа гарагт “Капитал банкныг татан буулгах” шийдвэр гаргасан. Ийнхүү 165,257 харилцах данс эзэмшигч, 56,164 хадгаламжийн данс эзэмшигчтэй банкны үйл ажиллагаа зогссон. Капитал банк бол банкны системдээ 1.1 хувийн активыг бүрдүүлдэг жижиг банк. Гэхдээ манай санхүүгийн салбарын 90 гаруй хувийг банкны салбар бүрдүүлдэг.

Дүгнэлт тайлбар:

Монголд гурван жилийн хугацаатай ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжиж байгаа. Хөтөлбөр хэрэгжих хугацааны тал нь өнгөрөөд явж байгаа. Өнгөрсөн хугацаанд банкуудын активын үнэлгээг хийлгээд, өөрийн хөрөнгө дутуу байна үүнийгээ нэм гэсэн шаардлага тавьсан. Капитал банк өөрийн хөрөнгөө нэмж чадахгүй явсаар ирсэн ба үүссэн доголдлыг нь Монголбанк мэдэж байсан.

Их хэмжээний нийтийн мөнгө энэ банкинд байсан нь Сангийн сайдын мэдээллээр ил болсон. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар: “Үндсэндээ банкны үйл ажиллагаа доголдоод 4 орчим жил болоод байсан гэдгийг онцолж хэлмээр байна. Үүнтэй холбоотойгоор хэд хэдэн өрийн дарамт Засгийн газарт үүсч байгаа. Тэтгэврийн даатгалын 104 тэрбум төгрөг тэнд байршиж байсан. Мөн эрүүл мэндийн даатгалын 134.9 тэрбум төгрөг. Энэ хоёрыг нийлүүлэхэд 240 орчим тэрбум төгрөг нь даатгалын мөнгө байсан. 2007 оноос эхлэн бага хэмжээтэй байршиж байгаад 2013, 2014 онд 100, 100 тэрбум төгрөгөөр нэмэгдээд одоогийн хэмжээндээ ирсэн. 2016 оноос хойш энд ямар нэгэн мөнгө нэмж байршуулаагүй. Мөн Хөгжлийн банкны 52 тэрбум төгрөг. Хөгжлийн банкны захирлаар Мөнхбат гэдэг хүн ажиллаж байх үед 2014-2015 онд дамжуулан зээлдэхээр гаргасан мөнгө. ЖДҮХС-ийн 47 тэрбум төгрөг



КАПИТАЛБАНК

МОНГОЛ УЛСЫН АРИЛЖААНЫ АНХНЫ БАНК

мөн байсан. Эдгээрийг нэмэхээр 340 гаруй тэрбум төгрөг болж байгаа. Дээр нь АШУҮИС-ийн 4, Боловсролын их сургуулийн 2 тэрбум төгрөг Капитал банкинд байсан.”

Энэ үйл явдал Монгол улсын төрийн мөнгө хаана байрших вэ гэдэг асуулыг гаргаж байна. Уг нь Монгол улсын төр Төрийн сан гэдэг нэртэй өөрийн банкттай. Энэ нь арилжааны банк шиг биш, зөвхөн харилцах дансны үйл ажиллагаа явуулдаг. Нийтийн хөрөнгийг арилжааны банкуудад байршуулахдаа ямар дүрэм, журам баримтлах ёстойг тодорхой болгох хэрэгтэй. Тэгэхгүй бол арилжааны банкууд өндөр хүү амлаж төрийн мөнгийг өөр дээрээ байршуулах гэж “зодолдож” байна. Нийтийн, том хэмжээтэй мөнгө арилжааны банкууд руу орж байгаа л бол Монголбанк шалгаж байх ёстой. Гэтэл шалгаагүй өнгөрсөн байна. Ингээд явж явж төрийн бүх алдагдлыг Должин эмээ авч байгаа талхнаасаа төлөөд байгаа байхгүй юу.

20 хүртэлх сая төгрөгийн хадгаламжийг Хадгаламжийн даатгалын корпораци өгнө, энэ нь Капитал банкны нийт хадгаламж эзэмшигчдийн 99.5 хувь. Үлдсэн 20 саяас дээш төгрөгийн хадгаламжтай иргэд 60 хоногийн дотор өргөдөл өгнө, түүнээс хойш 90 хоногийн дотор Монголбанкны томилсон эрх хүлээн авагч нь татан буугдсан банкны хөрөнгийг зарж, хуучин

зээлийг төлүүлэх байдлаар иргэдийн мөнгийг өгнө. Энэ хооронд тэр зээлүүд нь хувьцаа эзэмшигчидтэй нь холбоотой байна уу гэдэг нь гол асуудал. Хэрвээ холбоотой байвал тухайн компанийн эзний хөрөнгө рүү орно гэсэн үг. Энэ банкны хувьд хамгийн том хувьцаа эзэмшигч нь өөрөө гүйцэтгэх захирал хийж байсан учраас

тухайн эзний хөрөнгө рүү орох эрсдэл өндөр.

Капитал банк банкны системдээ 1.1 хувийн активыг бүрдүүлдэг учраас банкны системээ тэр чигээр нь хамрахгүй гэсэн үг. Харин хуулиар тогтоосон бүх дүрэм журмыг заавал чанд мөрдөж ажиллах ёстой гэсэн мессеж бусад арилжааны банкуудад очиж байгаа гэж ойлгох хэрэгтэй.

БАГШИЙН ХӨГЖИЛ – УЛСЫН ХӨГЖИЛ

Үйл явдлын товч:

4-р сарын 11-12-ны хооронд монголын багш нарын 7-р их хурал Төрийн ордонд болсон. Нийслэл, аймаг, орон нутаг дахь цэцэрлэг, сургуулийн багш нар, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод зэрэг боловсролын салбарын төлөөлөгчдийг өргөн хамруулсан хурал болсон. Хурлын гол зорилго бол багш нарын дуу хоолойг өргөн хүрээнд хүргэх. Нөгөө талаас харьяалах яамнаас салбарын гол бодлого, ажлаа салбарын төлөөлөгчид болон багш нарт танилцуулах.

Дүгнэлт тайлбар:

Хорин гурван жил завсарлаад багш нар их хурлаа хийж байна. Хүн ам зүйн нэгэн үе болох энэ хугацаанд боловсролын салбарын хүрээ, хууль эрх зүйн орчин, бүтэц тогтолцоо, сургалтын хөтөлбөр ихээхэн өөрчлөгдөж ирлээ. Монголын хүн ам нэг саяар нэмэгдэж 3.2 сая болов. Боловсролын тухай хуулиа бид сүүлийн 16 жилд 24 удаа өөрчилж, 300 заалтыг шинэчилсэн нь салбарын бодлого ямар савалгаатай явж ирснийг харуулж байна. Одоо нэг тогтож, өнгөрснөө дүгнэж, ирээдүйгээ төлөвлөх цаг ирлээ.

Юуны өмнө Монгол улс боловсролын салбарт оруулж буй хөрөнгө оруулалт, зардлаа яаралтай нэмэх, төсвийн сургуулиудынхаа материаллаг баазыг сайжруулж багш нарынхаа суурь цалинг өсгөх, түүний дотор бага ангийн, сургуулийн өмнөх насны багш нарын цалинг түлхүү нэмэх цаг болжээ.

Боловсрол бол нийгмийн тэгш бус байдлыг арилгаж, тэнцвэржүүлдэг хэрэгсэл. Тийм учраас улс орон даяар ижил хөтөлбөрөөр сургах, төсвийн хөрөнгийг хувийн сургуульд зарцуулахыг



царцааж, төрийн өмчийн сургуульд шилжүүлэх, гуравдугаар ээлжийг яаралтай халах, яваандаа 2 ээлжээ ч болих бодлого барих хэрэгтэй байна.

Зарим улс орнуудын боловсролын зардал, эзлэх хувиар, 2015 оны байдлаар

Улс	ДНБ-д	Төсвийн зарлагад
Эстони	5.2	13.0
Финланд	7.1	12.5
Израиль	5.9	15.0
Монгол	4.2	12.4

Эх сурвалж: Дэлхийн Банк

Энэ чиглэлийн ажилд туслаж, ЕБС-д хөрөнгө оруулсан компаниудын зарцуулсан хөрөнгийг зардалд нь тооцох, татвараас чөлөөлж болох юм. Улс орны бүсчилсэн хөгжлийн бодлогыг сэргээж, бүсийн төвүүдэд санхүүгийн эрх мэдлийг шилжүүлж, багш нарыг бэлтгэх төв, их дээд сургууль, салбарыг байгуулах шаардлагатай байна. Зөвхөн тэгж л хүн амын төвлөрлийг сааруулна.

ТӨМӨР ЗАМАА ЭХЛЭЭД ХААШАА ТАВИХ ВЭ?

Үйл явдлын товч:

Өнгөрсөн Лхагва гарагт Засгийн газрын ээлжит хуралдаанаар Тавантолгой- Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замыг барих шийдвэр гаргасан. Энэ ажлыг хийхийн тулд монголын төмөр зам компани бонд гаргаж, 750 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрдэнэс Таван толгойн 2018 оны цэвэр ашгаас гаргахаар боллоо. Харин төмөр замыг барих ажлыг Монгол улсын зэвсэгт хүчний жанжин штаб хийнэ гэлээ. Ингэснээр 3 дахин хямд өртгөөр буюу 1 км замыг 1.2 сая ам.долларын өртгөөр барина гэсэн тайлбарыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан өглөө.

Дүгнэлт тайлбар:

Уг нь бид нар урагшаа төмөр зам бариад эхэлчихсэн шүү дээ. Дуусгаагүй л болохоос. Эхэлсэн ажлаа дуусгаагүй байж одоо өөр чиглэлд барина гэж юу ярина вэ. 280 сая доллараар яг юу хийсэн бэ?

Монгол улс төмөр замын холимог царигийг тавьж чадвал дэлхийн худалдаанд эзлэх ач холбогдлоороо 1869 онд нээгдсэн Суэцийн, 1914 онд нээгдсэн Панамын суваг шиг түүхэн шинэ “суваг” болох гайхамшигт боломж байгаа. Оросын болон Хятадын галт тэрэг монголын нутагт орж ирээд дугуйгаа солихгүй буцаад гараад явж болдог “Ж” хэлбэрийн төмөр замын тээврийн сүлжээг бид байгуулж, хөндлөн төмөр замаа “холимог царигаар” барих хэрэгтэй.



Зөвхөн монголын өмч байх хөндлөн тэнхлэгийн төмөр замаа нэг дэр модон дээр дөрвөн шугам байх буюу өргөн, нарийн царигийн аль ч галт тэрэг чөлөөтэй явахаар хийх юм. Яг ийм холимог төмөр замыг Швед, Финландын хил дээр Хапаранда болон Торнио хотын хооронд хоёр км зайд гүүрэн дээгүүр бариад олон жил ашиглаж байна. Олон улсын худалдааны транзит тээврийг хурдан, хямдхан, аюулгүй өнгөрүүлж чаддаг болчихвол биднээс юу ч гарахгүй бөгөөд хураамж нь дангаараа монголыг баяжуулна. Тэгж чадвал бид газрын баялгаа өөрийн хэрэгцээнд зориулж олборлон, үнэ цэнэ нэмж боловсруулан хамгийн ашигтайгаар борлуулж чадна. Тэгээд ч бид хөршүүдээсээ биш хөршүүд биднээс хамаардаг цаг ирнэ. Бид хоёр хөршийн сонирхлыг тэнцүүлж чадах сайхан боломж бий болно.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв

Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.

GOOGLE STORE

APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл

www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Баатарчулууны Анударь

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com